



**НИЙСЛЭЛИЙН
НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

「 Спортын тэмцээн зохион байгуулах тухай 」

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/586 дугаар захирамжаар батлагдсан “Нийтийн тээврийн бодлогын газрын дүрэм”-ийн 7.1.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын хамт олныг биеийн тамир спортоор хичээллүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, шилдэг баг тамирчдыг тодруулан алдаршуулах, байгууллагын шигшээ баг бүрдүүлэх зорилгоор байгууллагын 2026 оны “Спортын аварга шалгаруулах тэмцээн”-ийг 2026 оны 04 дүгээр сарын 30, 05 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Тэмцээний удирдамжийг нэгдүгээр, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж шаардагдах хөрөнгийн зардлыг Ахлах нягтлан бодогч (Э.Хишигжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Тэмцээнийг зохион байгуулах, бэлтгэл ажлыг сайтар ханган ажиллахыг Спорт хамтлагийн ахлагч (З.Цэвээндорж)-д даалгасугай

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.БИЛГҮҮН



Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2026 оны 04 дүгээр сарын 15 -ны
өдрийн 1131 дүгээр тушаалын
нэгдүгээр хавсралт

**“НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН
2026 ОНЫ СПОРТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ТЭМЦЭЭН”-ИЙ УДИРДАМЖ**

Нэг. Ерөнхий зүйл

Энэхүү тэмцээний зорилго нь байгууллагын хамт олныг биеийн тамир спортоор хичээллүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, шилдэг баг тамирчдыг шагнаан урамшуулах, байгууллагын шигшээ баг бүрдүүлэхэд оршино.

Хоёр. Тэмцээний төрлүүд

Тэмцээнийг дараах төрлүүдээр зохион байгуулна.

1. Сагсан бөмбөг (эрэгтэй, эмэгтэй баг)
2. Гар бөмбөг (эрэгтэй, эмэгтэй баг)
3. Дартс (эрэгтэй, эмэгтэй баг)
4. Ширээний теннис (эрэгтэй, эмэгтэй баг)
5. Шатар (эрэгтэй, эмэгтэй баг)
6. Буухиа (холимог баг)

Гурав. Зохион байгуулалт, хамрах хүрээ, явагдах хугацаа

3.1. Тэмцээнд оролцох төрөл, тамирчдын тоо, хугацаа

№	Тэмцээний төрөл	Оролцох тамирчид	Хугацаа
1	Сагсан бөмбөг	Эрэгтэй - 7 Эмэгтэй - 7	2026.05.01
2	Гар бөмбөг	Эрэгтэй - 7 Эмэгтэй - 7	2026.04.30
3	Дартс	Эрэгтэй - 3 Эмэгтэй - 3	2026.04.30
4	Ширээний теннис	Эрэгтэй - 3 Эмэгтэй - 3	2026.04.30
5	Шатар	Эрэгтэй - 3 Эмэгтэй - 3	2026.04.30
6	Буухиа	Нийт 6 тамирчин Эрэгтэй - 3 Эмэгтэй - 3	2026.05.01

3.2. Уг тэмцээнд Нийтийн тээврийн бодлогын газрын албан хаагчдыг 5 багт хэлтэс нэгжээр хуваагдаж баг бүрдүүлэн оролцоно.

Дөрөв. Тэмцээний заавар

4.1 Сагсан бөмбөгийн тэмцээнд эрэгтэй 7, эмэгтэй 7, байх ба талбай дээр эрэгтэй 5, эмэгтэй 5, Гар бөмбөгийн тэмцээнд эрэгтэй 7, эмэгтэй 7 байх ба талбай дээр эрэгтэй 6, эмэгтэй 6, Дартсын тэмцээнд эрэгтэй 3, эмэгтэй 3, Шатарын тэмцээнд эрэгтэй 3, эмэгтэй 3, Ширээний теннисний тэмцээнд эрэгтэй 3, эмэгтэй 3,

Буухиа тэмцээнд нийт 6 тамирчин эрэгтэй 3, эмэгтэй 3 бүрэлдэхүүнтэйгээр оролцоно. Цөөн ажилтантай хэлтэс, нэгжүүд нэгдэн баг бүрдүүлэн тэмцээнд оролцож болно.

4.2.Тэмцээнд оролцох баг, тамирчид хувийн дугаар бүхий жигд хувцастай байна.

4.3.Тэмцээн эхлэх цагийг хатуу баримтлах бөгөөд тоглолт эхлэх цаг зарласнаас 5 минут хоцорсон тохиолдолд хожигдсоноор тооцон дараагийн тоглолтыг эхлүүлнэ.

4.4.Уг тэмцээний талбайн шүүгч зөвхөн тоглолттой холбоотой асуудлыг шийдэх ба бусад маргаантай асуудлыг зөвхөн багийн ахлагчаар дамжуулан ерөнхий шүүгч болон зохион байгуулагчдад тавьж шийдвэрлэнэ.

4.5.Тэмцээнд оролцогч багийн тооноос хамаарч оноо, хугацаа, тоглолтын систем, зохион байгуулалт зэргийг техникийн зөвлөгөөн дээр шийдвэрлэнэ.

Тав. Тэмцээний шагнал

5.1.Тэмцээний төрөл тус бүрд 1-ээс 3 дугаар байр эзэлсэн багт медаль өргөмжлөл, мөнгөн шагнал гардуулна.

5.2.Тэмцээнд оролцсон багуудын нийлбэр дүнгээр тэргүүлсэн хэлтэс, нэгжийг шалгаруулж “Шилжин явах цом”, өргөмжлөл, мөнгөн шагнал гардуулна.

Зургаа. Техникийн зөвлөгөөн, тэмцээний мэдүүлэг

6.1.Тэмцээнд оролцох баг тамирчдын мэдүүлгийг техникийн зөвлөгөөн дээр хүлээн авна.

6.2.Техникийн зөвлөгөөн 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 14:00 цагт тус газрын уулзалтын танхимд болно.

Долоо. Тэмцээн дүгнэх

7.1.Тэмцээний төрөл бүр дээр 1, 2, 3 дугаар байр шалгаруулж, багийн дүнг төрөл тус бүрээр нэгтгэж, нийлбэр дүнгээр байр эзлүүлэн шагнаж урамшуулна.

7.2.Тэмцээний төрөл тус бүрд

1-р байр: Өргөмжлөл, алтан медаль, мөнгөн шагнал


2-р байр: Өргөмжлөл, мөнгөн медаль, мөнгөн шагнал

3-р байр: Өргөмжлөл, хүрэл медаль, мөнгөн шагнал олгоно.

7.3.Тэмцээнд оролцогч багуудын 6 төрлийн тэмцээний нийлбэр дүнгээр нь их онооны системээр байр эзлүүлж, түрүүлсэн багт шилжин явах цом гардуулж, өргөмжлөл, мөнгөн шагнал олгоно.

7.4.Багуудын оноо тэнцсэн тохиолдолд медалийн чанараар шийднэ.

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2026 оны 04 дүгээр сарын 15-ны
өдрийн 1131 дүгээр тушаалын
хоёрдугаар хавсралт



Спортын арга хэмжээний зардлын төсөв

2026 оны 04 дүгээр сарын 13

Улаанбаатар хот

Хүснэгт №1 Спортын арга хэмжээний зардлын төсөв

	Зардлын төрөл	Тоо	Нэгжийн үнэ	Нийт үнэ /төгрөг/
1	Заалны тэмцээн шүүх шүүгчийн зардал	2	100,000	200,000
2	Өргөмжлөл/багийн дүн/	3	60,000	180,000
3	Өргөмжлөл /төрлөөр/	18	15,000	270,000
4	Медаль	156	12,000	1,872,000
5	Шүүгчийн хоолны зардал	2	50,000	100,000
6	Зохион байгуулалтын бусад зардал	1	500,000	500,000
7	Сагсан бөмбөг /шагналын сан/	3		300,000
8	Гар бөмбөг /шагналын сан/	3		300,000
9	Шатар /шагналын сан/	3		230,000
10	Теннис /шагналын сан/	3		230,000
11	Дартс /шагналын сан/	3		230,000
12	Буухиа/шагналын сан/	3		230,000
13	Багийн дүн /шагналын сан/	1		500,000
14	Нээлтийн үйл ажиллагаа	1		300,000
15	Анонс	1		300,000
Нийт зардлын дүн				<u>5,742,000</u>